



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 07 өдөр

Дугаар

A/29

Онги

Автотээврийн хэрэгслийн шинэчилсэн  
бүртгэл, үзлэг тооллогыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59.1.1, 59.1.23 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт “ Авто тээврийн тухай ” хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.1.3 дахь заалт, Аймгийн засаг даргын 2023 оны 03-р сарын 30-ны өдрийн А/174 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖИЛАХ нь:

1.Сумын хэмжээнд Автотээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, тооллогын ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс 04 сарын 24-ний өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2.Автотээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, тооллого зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Болоржаргал ( Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд : Ш. Ууганбаяр ( Цагдаагийн хэсгийн төлөөлөгч )

Р.Тунгалагтуяа ( Санхүү албаны дарга )

Г.Пүрэв ( Онги багийн Засаг дарга )

П.Энхсайхан ( Мааньт багийн Засаг дарга )

Б.Ган-Оргил ( Найз багийн Засаг дарга )

Х.Энхтайван ( Төгрөг багийн Засаг дарга )

3.Сайхан-Овоо сумын нутаг дэвсгэрт бүртгэлтэй “Автотээврийн үндэсний төв”ТӨҮГ-аас ирүүлсэн жагсаалтад тусгагдсан сүүлийн 1-4 жилийн хугацаанд техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй тээврийн хэрэгслүүдийг шинэчилсэн бүртгэл, тооллогод бүрэн хамруулах, шаардлагатай мэдээ, мэдээллийг тухай бүрд гарган холбогдох газарт мэдээлж ажмллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

4. Автотээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, тооллогын ажлыг холбогдох хууль, журмын хүрээнд үр дүнтэй зохион байгуулан хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Засаг даргын Тамгын газрын дарга (С.Болоржаргал)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Г.ЛУВСАНРАГВАА